



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



GREEN
CLIMATE
FUND



Холбоо барих хаяг:



Маргад төв 303 тоот, 8-р хороо, Сүхбаатар
дүүрэг, Улаанбаатар, Монгол улс



+976-77091142



NAPMongolia19@gmail.com



NAP Mongolia

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД
ДАСАН ЗОХИЦОХ ТӨЛӨВЛӨЛТИЙН ПРОЦЕССЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДЭСНИЙ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ**

MNG-RS-004

Төслийн товч танилцуулга



Төслийн зорилго:

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгоход оролцох талуудын институцийн болон техникийн чадавхыг үндэсний ба орон нутгийн хэмжээнд бэхжүүлэхэд оршино.

Үр дүн

Уг төслийн хэрэгжүүлснээр уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдал буурч, түүнд дасан зохицох арга хэмжээнүүдийг улс, аймгийн хэмжээний төлөвлөлтөд нэгтгэн оруулна. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийг улс, аймаг, сумын түвшинд боловсруулан, улмаар тэргүүлэх чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд хяналт шинжилгээ хийх чадвартай болно.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг боловсруулах, шинэчлэх, солилцох систем бэхэжсэн байна.
- Монгол Улсын Засгийн газар нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн дунд болон урт хугацааны санхүүжилтийн стратегийг боловсруулах чадвартай болно.
- Гол хэрэгжүүлэгч болон оролцогч талууд нь дасан зохицох төлөвлөлтийн үр дүнд хяналт шинжилгээ хийх, түгээх чадвартай болно.

Үндэсний дасан зохицох төлөвлөлтийн процесс (ҮДЗТ)

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг (үе шат, оролцогч талууд болон тэдгээрийн үүрэг г.м) тодорхойлон боловсруулах;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний хувилбарууд болон тэргүүлэх салбаруудыг тодорхойлох;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар бодлого, стратегийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.



- Уур амьсгалын мэдээллийн тогтвортой системийг бий болгох;
- Дасан зохицох нэн тэргүүний хувилбаруудын өртөг-өгөөжийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх.



- Урт хугацааны дасан зохицох төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн хэрэгцээг үнэлэх;
- Дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох стратегийг боловсруулах.

- ҮДЗТ-ийн процессын хяналт шинжилгээний системийг боловсруулах;
- ҮДЗТ-ийг хянах, үнэлэх, сайжруулах тогтолцоог хэрэгжүүлэх техникийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтуудыг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- ҮДЗТ-ийн үйл явц, боловсруулалт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт-шинжилгээний ажлуудын үр дүн, ололт амжилтуудын талаар олон улсын болон үндэсний хэмжээнд танилцуулах.